


ᠳᠣᠷᠨᠣᠭᠣᠪᠢ ᠠᠶᠢᠮᠦᠯᠠᠳᠤ
ᠰᠤᠲᠤᠰᠲᠢᠬᠢᠶᠢᠨ ᠬᠡᠯᠲᠦᠰ
STATISTICAL DIVISION AT GOVERNOR
OF DORNOGABI AIMAG



ДОРНОГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС
STATISTICAL DIVISION AT GOVERNOR
OF DORNOGABI AIMAG



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАНИЛЦУУЛГА 2015

2016 он

ГАРЧИГ

ОРШИЛ.....3

БҮЛЭГ I. ИНФЛЯЦИ

1. Инфляци, түүний өөрчлөлт нөлөөлөх хүчин зүйл5

2. Инфляцийн дундаж түвшин.....6

БҮЛЭГ II. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

3. Хэрэглээний үнийн индекс, түүний өөрчлөлт6

4. Дорноговь аймгийн хэрэглээний үнийн индекс, түүний өөрчлөлт.....7

5. Зарим гол нэрийн барааны үнийн өөрчлөлт12

6. Дорноговь аймгийн өргөн хэрэглээний зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ.....14

7. Дүгнэлт
.....15

ХҮСНЭГТ ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Инфляцийн түвшин, 2012-2015 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр

Хүснэгт 2. Инфляцийн дундаж түвшин

Хүснэгт 3. Хэрэглээний үнийн индекс, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2012-2015 хувь

Хүснэгт 4. Хэрэглээний үнийн ерөнхий индекс, Дорноговь аймаг 2015 оны байдлаар

Хүснэгт 5. Аймагийн төвүүдэд худалдаж буй 1 литр автобензин, дизелийн түлшний жижиглэн худалдаалах үнийн дундаж 2012-2015 оны байдлаар

Хүснэгт 6. Дорноговь аймгийн өргөн хэрэглээний зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ

Зураг 1. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс

Зураг 2. Мах, махан бүтээгдэхүүний үнийн Дорноговь аймгийн индекс

Зураг 3. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс

Зураг 4. Төмс, хүнсний ногооны үнийн Дорноговь аймгийн индекс

Зураг 5. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс

Зураг 6. Талх, гурил, будааны бүлгийн үнийн Дорноговь аймгийн индекс

Зураг 7. Дорноговь аймагт худалдаалагдаж байгаа гурилын үнийг жилийн дундаж үнээр

Зураг 8. Дорноговь аймагт борлуулж буй 1 литр автобензин болон дизелийн түлш жилийн дундаж үнээр:

ОРШИЛ

Уг танилцуулгаар Дорноговь аймгийн хэрэглээний үнийн өөрчлөлтийг хэрэглэгчдэд хүргэх, зарим бараа үйлчилгээний үнийг мэдээллийг харуулах, инфляцийн өсөлт бууралтад үнэ хэрхэн нөлөөлж байгаа зэргийн харуулах зорилготой.

Инфляци гэдэг нь: үнийн ерөнхий түвшин өсөж мөнгөний худалдан авах чадвар буурах үзэгдэл юм.

Инфляцийн түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс (ХҮИ) болдог ба үнэ нэмэгдэж, тэр хэмжээгээр мөнгөний ханш буурахыг инфляци гэнэ.

УБСЕГ нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон нийтийн хүртээл болгож байна.

ҮСХ/хуучин нэрээр/ хэрэглээний үнийн индексийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын аргачлалын дагуу 1991 оноос эхлэн тооцсон ба, 2008 он хүртэл Улаанбаатар хотын ХҮИ-ээр хэрэглээний үнийн улсын индексийг /ХҮУИ/ төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн. 1991 оноос хойш ХҮИ тооцдог хэрэглээний сагсны нэр төрөл, жин болон суурь үеийг 4 удаа шинэчлээд байна.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан ХҮУИ-ийн тооцоонд аймгийн ХҮИ-ийг оруулах шаардлагатай болсон. 2008 оны 1 дүгээр сараас эхлэн ХҮУИ-ийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

Өрхийн нийгэм эдийн засгийн 2010 оны судалгааны үр дүнгээр хэрэглээний зардлын жинг шинэчлэн 2010 оны 12 дугаар сарын суурь үетэй харьцуулснаар 2012 оны 1 дүгээр сараас хэрэглээний үнийн индексийг тооцон нийтэд мэдээлж байна.

Махны дундаж үнийг илүү бодитой болгох үүднээс худалдааны зах, цэгүүдийн борлуулалтын хэмжээг тодорхойлох тусгайлсан судалгаа явуулж, үр дүнд нь махны дундаж үнийг жигнэж тооцдог болсон. Энэхүү арга зүйн өөрчлөлтийг ХҮИ тооцох аргачлалд тусган, 2014 оны 1 дүгээр сараас эхлэн шинэчилсэн аргачлалын дагуу тооцсон ХҮИ-ийг тархааж байна.

ХҮИ нь хүн амын өргөн хэрэглэдэг бараа, үйлчилгээний үнэ, тарифыг тэдгээрийн хэрэглээгээр жигнэсэн дундаж үзүүлэлт юм. ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн 2 үзүүлэлтийг ашигладаг. Сагсанд багтдаг бараа үйлчилгээнүүдийн үнийн өөрчлөлтийг тооцоход бараа үйлчилгээнүүдийн тоо хэмжээ, чанарыг тогтмолоор авч

үздэг. ХҮИ нь нийт өрхүүдийн хувьд тооцсон инфляцийн (үнийн өсөлт) дундаж түвшнийг харуулдаг харин нэг өрхийнхийг харуулахгүй. Өрх болгон өөрийн зарлагын бүтэцтэй түүнчлэн бараа, үйлчилгээний үнүүд нь ялгаатай хэмжээгээр өөрчлөгддөг учраас үнийн өсөлт өрх бүрт ижилхэн нөлөөлдөггүй. Хэрэв тухайн өрхийн мөнгөн зарлагын дийлэнх хувийг эзэлдэг бараа, үйлчилгээний үнэ өсвөл инфляцийн нөлөөллийг ихээр мэдрэнэ. Харин үнэ нь харьцангуй тогтвортой бараа, үйлчилгээнд нийт зардлынхаа дийлэнх хэсгийг зарцуулсан бол тэр өрхөд үнийн өсөлтийн нөлөөлөл бага мэдрэгдэнэ.

Хэрэглээний сагс гэдэг нь дундаж орлоготой өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Хүн амын тархалт, нас хүйсийн бүтэц, өрхийн орлогын түвшин, бараа, үйлчилгээний чанар зэрэг хүчин зүйлийн өөрчлөлтөөс өрхийн хэрэглээний бүтэц байнга өөрчлөгдөж байдаг. Үүнтэй уялдуулан хэрэглээний сагсны нэр төрлийг шинэчлэх шаардлагатай болдог.

2012 оны 1 дүгээр сараас эхлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу Улаанбаатар хотод 329 (аймгуудад 214 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр ХҮИ-ийг тооцож байна.

Мөн аймгийн үнэ дотроо тухайн аймгийн хүн амын нягтаршил ихтэй 5 сумыг /Дорноговь аймгийн Айраг, Даланжаргалан, Замын-Үүд, Эрдэнэ, Хатанбулаг / сонгон авч 214 нэр төрлөөр үнэ цуглуулан мэдээлж байна.

Аймгийн төвийн сумаас 238 нэр төрөлтэй болон 214 нэр төрөлтэй 2 сагсаар үнийн мэдээллийг сүүлийн 2 жил цуглуулан мэдээлж байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин гэдэг нь өрхийн худалдаж авсан бараа, үйлчлүүлсэн үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь юм. Бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт нь хэрэглэгчийн зарцуулсан зардлын дүнд хэрхэн нөлөөлөхийг энэ жин илэрхийлнэ.

Хэрэглээний үнийн индексийн тооцоог өмнөх сарынхтай, өмнөх оны эцсийнхтэй, өмнөх оны мөн үеийнхтэй, суурь үетэй харьцуулсан байдлаар хугацааны хувьд 4 түвшинд тодорхойлдог.

1. Инфляци

Инфляци гэдэг нь: үнийн ерөнхий түвшин өсөж мөнгөний худалдан авах чадвар буурах үзэгдэл юм.

Хэрэглээний үнийн улсын индекс өмнөх оныхоос 2012 оны эцэст 14.0 хувь, 2013 онд 12.5 хувь, 2014 онд 11.0 хувиар өссөн бол 2015 онд 1.9 хувиар өсч, өсөлтийн хурдац 2014 оныхоос 9.1 пунктээр саарлаа.

Хүснэгт 1. ИНФЛЯЦИЙН ТҮВШИН, 2012-2015 оноор, хэрэглээний бараа, үйлчилгээний бүлгээр :

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2012	2013	2014	2015
Хүнсний бараа, ундаа, ус	29.3	17.5	13.3	8.4	-6.1
Согтууруулах ундаа, тамхи	3.2	54.4	13.4	10.3	1.4
Хувцас, бөс бараа, гутал	16.1	16.1	17.6	14.3	5.5
Орон сууц, ус, цахилгаан, түлш	12.3	11.0	7.8	16.3	3.2
Гэр ахуйн тавилга, бараа	4.7	10.2	18.2	11.5	5.1
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	9.0	13.2	9.1	4.1
Тээвэр	12.2	6.5	3.0	8.6	1.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-1.5	-0.3	0.0	-0.8
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.8	3.5	0.3	8.1	2.4
Боловсролын үйлчилгээ	4.7	15.2	27.2	16.8	23.1
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	2.6	23.0	17.8	8.6	4.4
Бусад бараа, үйлчилгээ	4.1	7.4	17.2	11.8	5.1
Ерөнхий индекс	100.0	14.0	12.5	11.0	1.9

Инфляци 2015 оны жилийн эцэст 2011 оныхоос 45.0 хувиар өссөн байна. Үүний 10.7 нэгж (23.8 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 10.4 нэгж (23.0 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 5.6 нэгж (12.3 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 5.3 нэгж (11.7 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 онд 1.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн улсын индексийн 2015 оны 1.9 хувийн өсөлтийн 1.3 нэгж нь боловсролын бүлгийн; 1.0 нэгж хувцас, гутал, бөс барааны бүлгийн; 0.4 нэгж нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Инфляцийн дундаж түвшин:

Он	хувь			
	2012	2013	2014	2015
Инфляцийн жилийн дундаж түвшин	14.3	10.5	12.8	6.6

2015 оны 12 сард ХҮУИ 101.9 хувь гарсан нь 2015 оны хувьд жилийн инфляци хамгийн бага гарсан сар байв. 2015 оны 1 сард 109.3 хувь байсан нь хамгийн их өсөлт байлаа.

2. Зарим гол нэрийн бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь:

Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хүснэгт 3. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, өмнөх оныхтой харьцуулснаар, аймаг, нийслэлээр, 2012-2015, хувь

Аймаг, нийслэл	2012	2013	2014	2015
Ерөнхий индекс	114.0	112.5	111.0	101.9
Баруун бүс				
Баян-Өлгий	114.4	115.0	111.2	96.2
Говь-Алтай	113.3	109.1	109.5	102.3
Завхан	120.6	115.1	110.0	104.1
Увс	112.7	108.8	115.2	103.2
Ховд	117.0	109.3	113.7	99.2
Хангайн бүс				
Архангай	118.6	108.7	117.1	111.9
Баянхонгор	119.1	114.5	112.3	106.4
Булган	107.7	121.6	110.4	101.7
Орхон	119.5	115.3	112.7	100.6
Өвөрхангай	109.3	116.6	112.9	107.0
Хөвсгөл	114.0	108.9	111.8	102.3
Төвийн бүс				
Говь-Сүмбэр	123.7	115.3	108.4	105.9
Дархан-уул	110.7	110.8	108.5	100.0
Дорноговь	113.8	118.6	110.3	97.7
Дундговь	109.0	114.4	111.2	104.0
Өмнөговь	112.1	116.1	109.9	101.4
Сэлэнгэ	112.4	108.1	110.6	102.4
Төв	113.2	112.8	109.4	106.1
Зүүн бүс				

Дорнод	116.7	110.7	110.7	105.4
Сүхбаатар	109.9	110.1	111.3	104.4
Хэнтий	109.7	111.2	111.7	100.2
Улаанбаатар				
Улаанбаатар	114.2	112.3	110.7	101.1

Аймгуудад хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 оны жилийн эцэст өмнөх оныхтой харьцуулахад Баян-Өлгий, Ховд, Дорноговь аймгуудад 0.8-3.8 хувиар буурч, бусад аймгуудад 0.2-11.9 хувиар өссөний дотор Архангай аймагт 11.9 хувь нэмэгдсэн нь хамгийн өндөр үзүүлэлт байв

Хүснэгт 4. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ЕРӨНХИЙ ИНДЕКС, Дорноговь аймаг 2015 оны байдлаар :

Бараа үйлчилгээний бүлэг	ЖИН	2015-12	2015-12	2015-12
		2010-12	2014-12	2014-12
Ерөнхий индекс	100.0	158.0	97.7	97.7
Хүнсний бараа, ундаа, ус	36.0	145.9	87.8	87.8
Согтууруулах ундаа, тамхи	2.5	201.9	94.8	94.8
Хувцас, бөс бараа, гутал	18.0	224.8	105.2	105.2
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.6	143.2	100.6	100.6
Гэр ахуйн тавилга, бараа	6.2	147.7	104.7	104.7
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.6	118.7	98.0	98.0
Тээвэр	14.3	134.4	104.1	104.1
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.9	100.8	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.1	95.7	100.5	100.5
Боловсролын үйлчилгээ	0.2	339.3	126.4	126.4
Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	0.8	301.9	122.4	122.4
Бусад бараа, үйлчилгээ	3.9	157.6	101.0	101.0

Хэрэглээний үнийн ерөнхий индексийг өмнөх онотой харьцуулахад: 2.3 хувиар буурсан байна.

Ерөнхий индекс 2.3 хувиар буурахад: Хүнсний бараа ундаа усны бүлэг 12.2 хувиар, согтууруулах ундаа, тамхи 5.2 хувиар, эм тариа эмнэлэгийн үйлчилгээ 2.0 хувиар буурч, хувцас бөс бараа, гутал 5.2 хувиар, орон сууц ус цахилгаан түлш 0.6 хувиар, гэр ахуйн тавилга бараа 4.7 хувиар, тээвэр 4.1 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ 0.5 хувиар, боловсролын үйлчилгээ 26.4 хувиар, зочид буудал зоогийн газар 22.4 хувиар, бусад бараа үйлчилгээ 1.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн ерөнхий индексийг суурь онотой харьцуулахад: 58.0 хувиар өссөн байна.


Ерөнхий индекс 58.0 хувиар өсөхөд: Хүнсний бараа ундаа усны бүлэг 45.9 хувиар, согтууруулах ундаа 101.9 хувиар, хувцас бөс бараа гутал 124.8 хувиар, орон сууц ус цахилгаан түлш 43.2 хувиар, гэр ахуйн тавилга бараа 47.7 хувиар, эм тариа эмнэлэгийн үйлчилгээ 18.7 хувиар, тээвэр 34.4 хувиар, холбооны хэрэгсэл шуудангийн үйлчилгээ 0.8 хувиар, боловсролын үйлчилгээ 239.3 хувиар, зочид буудал зоогийн газар дотуур байр 201.9 хувиар, бусад бараа үйлчилгээ 57.6 хувиар өсч, амралт чөлөөт цаг соёлын бараа үйлчилгээ 4.3 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.

Өрхийн хэрэглээнд хүнсний бараа, үүн дотроо гурил, мах, махан бүтээгдэхүүн өндөр жин эзэлдэг. Үнийн өсөлтөд голлон нөлөөлдөг хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, бензин, шатахууны зэрэг хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг авч үзье.

Махны үнэ


Махны үнэ нийлүүлэлттэй холбоотойгоор байнга хэлбэлздэг бөгөөд хавар, зуны улиралд өсч, намар, өвлийн улиралд буурдаг хандлага 2012-2015 онд мөн хэвээр хадгалагдаж байна.

Зураг 1. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Өнгөрсөн дөрвөн жилд хонины махны 1 кг-ын үнэ хамгийн хямд буюу 2015 оны 12 дугаар сард 4100 төг байсан бол 2014 оны 5 дугаар сард хамгийн үнэтэй буюу 7800 төгрөгт хүрч байжээ.

Зураг 2. Мах, махан бүтээгдэхүүний үнийн Дорноговь аймгийн индекс (өмнөх оны 12 сар =100)




Өнгөрсөн дөрвөн жилд хонины махны 1 кг-ын үнэ хамгийн хямд буюу 2015 оны 12 дугаар сард 3833 төг байсан бол 2014 оны 3-6 дугаар сард хамгийн үнэтэй буюу 7500 төгрөгт хүрч байжээ.

Төмс, хүнсний ногооны үнэ

Сүүлийн жилүүдийн судалгаанаас харахад хавар, зуны улиралд хүнсний ногооны үнэ нь өсч, 8-10 дугаар сард ургац хураалттай холбоотойгоор үнэ нь хямдардаг.

2015 оны хувьд 7 дугаар сард төмс, хүнсний ногооны үнэ оны эхнээс 34.5 хувиар өссөн байна.


Зураг 3. Төмс, хүнсний ногооны үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Манай улс 2015 онд 72.3 мян.т хүнсний ногоо, 163.8 мян.т төмс хураасан нь 2014 оныхоос хүнсний ногоо 31.0 хувиар буюу 32.4 мян.тонноор буурч, төмс 1.4 хувиар буюу 2.3 мян.тонноор өссөн байв.

Улсын хэмжээнд жилийн дундаж үнээр 2013 онд хамгийн хямд буюу 938 төг, 2015 онд хамгийн өндөр буюу 1263 төг байна.

Зураг 4. Төмс, хүнсний ногооны үнийн Дорноговь аймгийн индекс (өмнөх оны 12 сар =100)




Дорноговь аймагт төмс хүнсний ногоо жилийн дундаж үнээр 2013 оны 9-10-р сард хамгийн хямд 450 төг байсан байна.

2015 оны 7 сард хамгийн өндөр буюу 1600 төг хүртэл өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь өмнөх оны үнэтэй харьцуулахад 49.9 хувиар өссөн байна.

Гурилын үнэ


2015 оны байдлаар Талх, гурил, будааны бүлгийн үнэ 2014 оны жилийн эцсийнхээс 6.5 хувиар өсчээ.

Зураг 5. Талх, гурил, будааны бүлгийн үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)



Энэхүү өсөлтөд гурилын дотоодын үйлдвэрлэл, импортын тоо хэмжээний өөрчлөлт нөлөөлжээ. 2014 онд Дотоодын гурил үйлдвэрлэлтийн хэмжээ 209.2 мян.тн байсан бөгөөд энэ нь 2014 оныхоос 8.4 хувиар буурсан. Гурилын импорт 2015 онд 20.5 мян.тн байсан ба 2014 оныхоос 17.1 хувиар өссөн байна.


Зураг 6. Талх, гурил, будааны бүлгийн үнийн Дорноговь аймгийн индекс (өмнөх оны 12 сар =100)



Дорноговь аймагт худалдаалагдаж байгаа алтан тариан дээд гурил 2012 оны 1-2 сард хамгийн хямд буюу 800 төг, 2015 оны 8-сараас хамгийн өндөр буюу 1217 төг болж өссөн байна.

Алтан тариан 1-р гурил 2012 оны 1-2 сард хамгийн хямд буюу 700 төг, 2015 оны 8-сараас хамгийн өндөр буюу 1100 төг болж, Алтан тариан 2-р гурил 2012 оны 1-2 сард хамгийн хямд буюу 550 төг, 2015 оны 8-сараас хамгийн өндөр буюу 883 төг болж өссөн байна.

Зураг 7. Дорноговь аймагт худалдаалагдаж байгаа гурилын үнийг жилийн дундаж үнээр харуулбал:



2015 оны жилийн дунджаар алтан тариан дээд гурил 1кг нь 1201 төг, алтан тариан 1-р гурил 1023 төг, алтан тариан 2-р гурил 864 төг байна.

Үүнийг 2014 оны жилийн дундажтай харьцуулахад алтан тариан дээд гурил 3.3 хувиар, алтан тариан 1-р гурил 10.7 хувиар, алтан тариан 2-р гурил 18.5 хувиар тус тус өссөн байна.

Автобензин, шатахууны үнэ

Инфляцийн өсөлтөнд бодитойгоор нөлөө үзүүлж буй нэг хүчин зүйл нь шатахууны үнийн өсөлт юм. Шатахууны үнэ бүхий л бараа, үйлчилгээний суурь үнэд нөлөөлдөг бөгөөд шатахууны үнэ нэмэгдэхэд нэг хэсэг нь бодитойгоор, нөгөө хэсэг нь үндэслэлгүйгээр бараа үйлчилгээнийхээ үнийг нэмэх хандлага ажиглагддаг. Шатахууны үнэ тогтвортой байх нь эдийн засагт сайнаар нөлөөлөх учир төрөөс шатахууны үнийн хэт өсөлтөөс хамгаалсан арга хэмжээнүүдийг авч явуулдаг билээ.

Аймгийн төвүүдэд худалдаж буй 1 литр автобензин, дизелийн түлшний жижиглэн худалдах үнийн дундажийг 2012-2015 оны байдлаар аймгаар зэрэгцүүлэн харуулбал:


Хүснэгт 5. Аймгийн төвүүдэд худалдаж буй 1 литр автобензин, дизелийн түлшний жижиглэн худалдаалах үнийн дундаж 2012-2015 оны байдлаар:

Аймаг	А80				А92				Дизелийн түлш			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
Архангай	1546	1611	1610	1610	1746	1771	1790	1790	1893	1933	1940	1363
Баян-Өлгий	1607	1547	1723	1616	1943	1885	1952	1874	1900	1859	1952	1876
Баянхонгор	1572	1625	1680	1635	1768	1804	1810	1810	1861	1884	1890	1890
Булган	1491	1541	1540	1540	1666	1691	1710	1710	1769	1781	1800	1800
Говь-Алтай	1635	1691	1705	1688	1973	2021	2040	2018	1980	2025	2040	2029
Дорноговь	1477	1528	1545	1537	1741	1785	1809	1798	1823	1884	1906	1890
Дорнод	1563	1627	1630	1623	1820	1857	1880	1862	1872	1907	1930	1918
Дундговь	1486	1559	1568	1561	1741	1791	1836	1806	1834	1871	1890	1886
Завхан	1639	1691	1688	1677	1935	1991	2010	1989	1927	1991	2010	2000
Өвөрхангай	1523	1572	1570	1588	1720	1722	1740	1740	1868	1893	1890	1890
Өмнөговь	1608	1630	1650	1650	1831	1871	1890	1890	1871	1891	1910	1910
Сүхбаатар	1588	1661	1660	1653	1857	1901	1920	1901	1892	1931	1950	1939
Сэлэнгэ	1473	1561	1585	1580	1688	1671	1693	1690	1786	1801	1824	1820
Төв	1488	1571	1570	1570	1640	1671	1688	1690	1732	1771	1788	1790
Увс	1632	1679	1670	1660	1904	1929	1940	1917	1908	1936	1944	1928
Ховд	1691	1756	1763	1745	1982	2046	2090	2057	1980	2046	2090	2068
Хөвсгөл	1593	1667	1670	1670	1887	1911	1940	1940	1934	1967	1990	1990
Хэнтий	1553	1591	1590	1589	1811	1821	1840	1828	1871	1881	1900	1893
Дархан-Уул	1474	1532	1550	1545	1624	1634	1660	1655	1710	1762	1790	1780
Орхон	1488	1563	1560	1560	1612	1641	1658	1660	1755	1771	1790	1790
Говьсүмбэр	1429	1470	1507	1527	1703	1731	1750	1750	1811	1832	1849	1844

Дорноговь аймагт худалдаалж байгаа А80 бензин 2012 онд хамгийн хямд 1477 төг, 2014 онд хамгийн үнэтэй буюу 1545 төгрөгөөр худалдаалагдсан байна.

Харин А92 бензин 2012 онд хамгийн хямд буюу 1741 төг, хамгийн үнэтэй 2014 онд 1809 төг, дизелийн түлш 2012 онд 1823 төг, 2014 онд хамгийн өндөр буюу 1906 төг байна.

Зураг 8. Дорноговь аймагт борлуулж буй 1 литр автобензин болон дизелийн түлш жилийн дундаж үнээр:



Дээрх зургаас харвал шатахууны үнэ 2014 он хүртэл өссөн үзүүлэлттэй харагдаж байна. Дээрх 4 оноос харахад 2012 онд хамгийн хямд буюу А80-1477төг

А92-1741 төг

Дизель-1823 төг байсан бол

Сүүлийн 4 жилийн хамгийн өсөлттэй буюу буюу А80-1545 төг

А92-1809 төг

Дизель-1906 төг байна.

Дорноговь аймагт шатахуун борлуулагч 5 компани үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдний Сайншанд суманд худалдаалж буй үнэ бүгд нэг түвшинд тогтоогддог. Аймгуудад худалдах шатахууны үнийг шатахуун борлуулагч компануудын дээд удирдлагын шийдвэрээр тогтоож аймгуудад хүргүүлдэг байна.

3. Дорноговь аймгийн өргөн хэрэглээний зарим бараа, үйлчилгээний жилийн дундаж үнэ:

Хүснэгт 6.

	2012	2013	2014	2015
Бараа үйлчилгээ	төг			
Гурил, 1-р зэрэг, кг	720	749	924	1023
Цагаан будаа, кг	1554	1728	2053	2123
Хонины мах, кг	5663	6454	6576	5619
Үхрийн мах, кг	6700	7583	8025	7350
Төмс, кг	797	683	894	1181
Байцай, кг	1399	1250	1222	1285
Лууван, кг	1174	1042	1292	1308
Манжин, кг	1033	958	1343	1636
Сонгино, кг	1200	1356	1339	1436
Халаалт, м2	198	247	495	495
Цэвэр усны үнэ, сард, 1 хүний	660	660	660	880

Цахилгаан 1квт.ц	83	84	91	107
Бензин А80	1477	1528	1545	1537
Бензин А92	1741	1785	1809	1798
Дизелийн түлш	1823	1884	1906	1890

Дээрх хүснэгтээс харахад гурил, цагаан будааны үнэ жилд нэг удаа өөрчлөгдсөн бөгөөд жилийн дундаж үнээр он онд өссөн үзүүлэлттэй байна. Харин мах болон хүнсний ногоо нийлүүлэлтээс хамаардаг бөгөөд хүнсний ногоо ихэвчлэн 8-10 сарын хооронд хямд харин мах 7сараас эхлэн хямдарч нийлүүлэлтээс шалтгаалан үнэ тогтоогддог.

Дүгнэлт:

Инфляци 2015 оны жилийн эцэст 2011 оныхоос 45.0 хувиар өссөн байна. Үүний 10.7 нэгж (23.8 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнийн өсөлтөөс, 10.4 нэгж (23.0 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс, 5.6 нэгж (12.3 хувь) нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс, 5.3 нэгж (11.7 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2015 онд 1.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 23.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 3.2 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний үнийн улсын индексийн 2015 оны 1.9 хувийн өсөлтийн 1.3 нэгж нь боловсролын бүлгийн; 1.0 нэгж хувцас, гутал, бөс барааны бүлгийн; 0.4 нэгж нь орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнийн өсөлтөөс голлон шалтгаалсан байна.

2015 оны 12 сард ХҮУИ 101.9 хувь гарсан нь 2015 оны хувьд жилийн инфляци хамгийн бага гарсан сар байв. 2015 оны 1 сард 109.3 хувь байсан нь хамгийн их өсөлт байлаа.

2015 оны 12 сард ХҮУИ 101.9 хувь гарсан нь 2015 оны хувьд жилийн инфляци хамгийн бага гарсан сар байв. 2015 оны 1 сард 109.3 хувь байсан нь хамгийн их өсөлт байлаа.

Дорноговь аймгийн хэрэглээний үнийн ерөнхий индексийг өмнөх онотой харьцуулахад: 2.3 хувиар буурсан байна.

Ерөнхий индекс 2.3 хувиар буурахад: Хүнсний бараа ундаа усны бүлэг 12.2 хувиар, согтууруулах ундаа, тамхи 5.2 хувиар, эм тариа эмнэлэгийн үйлчилгээ 2.0 хувиар буурч, хувцас бөс бараа, гутал 5.2 хувиар, орон сууц ус цахилгаан түлш 0.6 хувиар, гэр ахуйн тавилга бараа 4.7 хувиар, тээвэр 4.1 хувиар, амралт чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ 0.5 хувиар, боловсролын үйлчилгээ 26.4 хувиар, зочид буудал зоогийн газар 22.4 хувиар, бусад бараа үйлчилгээ 1.0 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа үйлчилгээнээс мах махан бүтээгдэхүүн нийлүүлэлтээс шалтгаалан үнэ өөрчлөгддөг бол төмс хүнсний ногоо зэрэг нь 8-10 саруудад ургац хураалтаас шалтгаалан үнэ буурдаг. Гурил, цагаан будаа, элсэн чихэр зэрэг нь жилдээ ойролцоогоор нэг удаа хэлбэлзэж өөрчлөгддөг бөгөөд энэ голдуу өссөн шинжтэй байдаг.

Мөн шатахууны үнийг аймаг орон нутгуудад ижил түвшинд тогтоодог бөгөөд үнийг дээд газраасаа судалгаа явуулж бусад шатахуун худалдаалагддаг газруудтай харилцан тохиролцож тогтоон орон нутгуудад худалдаалдаг байна.

Ашигласан ном зүй

1. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан - <http://www.1212.mn/>
2. Google.com
3. Дорноговь аймгийн бараа үйлчилгээний үнэ
4. Инфляцийн төлөв байдлын тайлан, 2016 он 3-р сар, Монгол банк / <http://www.mongolbank.mn/>
5. 2015 оны Статистикийн эмхэтгэл

Танилцуулга бэлтгэсэн: Г.Мөнхзул

2016 он